



МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН ТУШААЛ

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

Б.Саранчимэгийг түр орлон гүйцэтгэгчээр томилох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5.2, 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Чөлөөт бүсийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, “Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс”-ийн Захирагчийн ажлын албаны бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 83 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс”-ийн Захирагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Батсүхийн Саранчимэгийг томилсугай.

2.Б.Саранчимэгийн цалин, холбогдох нэмэгдлийг зохих журмын дагуу тооцож олгохыг “Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс”-ийн Захирагчийн ажлын албанд зөвшөөрсүгэй.

3.Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлж, хариуцлагатай ажиллахыг Б.Саранчимэгт үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Б.Мөнх-Оргилд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД



С.АМАРСАЙХАН

0025100448